



ХЭНТИЙ АЙМАГ
БАЯНХУТАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2029 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 02

Баянхутаг сум

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНХУТАГ СУМЫН
2024 ОНЫ ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9, 46.1, 46.2, 48.1 дэх заалтыг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12-р сарын 05-ны өдрийн 23 дугаар хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 18 дугаар ээлжит хуралдаанаас **ТОГТООХ нь:**

Нэг. Сумын 2024 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай:

/Мянган төгрөгөөр/

1.	Сумын төсвийн орлого бүгд	255033,1
1.1.	Татварын орлого	228233,1
1.1.1.	Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	128700,0 ✓
1.1.2.	Бууны албан татвар	500,0 ✓
1.1.3.	Улсын тэмдэгтийн хураамж	1000,0 ✓
1.1.4.	Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	54033,1 ✓
1.1.5.	Хөрөнгийн орлого	8000,0 ✓
1.1.6.	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	300,0 ✓
1.1.7.	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	7700,0 ✓

1.1.8	Орлогыг нь тухай бүрт тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар	18000,0 ✓
1.1.9	Үл хөдлөх хөрөнгийн татвар	3000,0
1.1.10	Газрын төлбөр	7000,0 ✓
1.1.11	Малын тоо толгойн албан татвар	0
1.2.	Татварын бус орлого	26800,0
	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого	9800,0 ✓
	Бусад орлого	16000,0 ✓
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1000,0 ✓

Хоёр. Сумын 2024 оны төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

/Мянган
төгрөгөөр/

Д/д	ТТЗ, түүний харьяа байгууллага	Орлогын дүн
2.1.	Сумын Засаг дарга	1000,0
2.1.1.	Байгууллага ЗДТГазар	
	Үүнээс: Төсвийн байгууллагын өөрийн орлого	1000,0

Гурав. Сумын 2024 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг **2265894,4** мянган төгрөгөөр баталж, төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

/Мянган төгрөгөөр/

3.1.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	182377,8
3.1.1.	Урсгал зардлын дээд хэмжээ	182377,8
3.2.	Засаг дарга	2083016,6
3.2.1	Засаг даргын Тамгын газар	1030979,7
3.2.1.1	Урсгал зардлын дээд хэмжээ	1030479,7
3.2.1.1.1	Үүнээс: Орон нутгийн байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал	338785,1

	ЕБСургууль	192472,7
	Цэцэрлэг	49608,4
	Соёлын төв	44686,5
	Эрүүл мэндийн төв	52017,5
3.2.1.2	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ /ОНХСан/	618365,6
3.2.1.2.1	Үүнээс: Их засвар	
3.2.2.1	Хоршоо хөгжүүлэх сан	94886,2
3.2.2.2	Байгаль хамгаалах сан	500,0
3.2.2.3		

Дөрөв. Сум 2024 оны төсвийн жилд сумын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг ОНХСангийн оны эхний үлдэгдлээс **80109,9** мянган төгрөг, үүнээс /2023 оны малын тоо толгойн албан татвар урьд оны үлдэгдэл **60000,0** сая төгрөг/ орлогын шилжүүлгийг **538255,7** мянган төгрөг, нийт **618365,6** мянган төгрөгөөр баталсугай.

Тав. . Сумын 2024 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг **2265894,4** мянган төгрөг буюу дор дурдсанаар баталсугай:

1. Сумын татварын болон татварын бус орлого **254033,1** мянган төгрөг
2. Сумын төсөвт Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг **1176836,6** мянган төгрөг
3. ОНХСангийн оны эхний үлдэгдлээс **80109,9** мянган төгрөг, Сумын төсөвт Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг **538255,7** мянган төгрөг, /Малын тоо толгойн албан татварын 2023 оны орлогоос **60000,0** сая төгрөг/ нийт **618365,6** мянган төгрөг
4. Сумын төсвийн урьд оны үлдэгдэл **120273,0** мянган төгрөг
5. Сумын төсвийн тухайн жилийн төсвийн байгууллагын өөрийн орлого **1000,0** мянган төгрөг
6. Хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлээс **54886,2** мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос **40000,0** сая төгрөг нийт **94886,2** мянган төгрөг
7. Байгаль хамгаалах сан туслах үйл ажиллагааны орлогоос **500,0** мянган төгрөг нийт **500,0** мянган төгрөг

Зургаа. "Сум төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт"-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Долоо. "Сумын төвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр-ийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Найм. "Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хуваарилалт"-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

Ес. "Сумын Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сангийн 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

Арав "Сумын хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг 5 дугаар хавсралтаар баталсугай.

ДАРГА

Д.ГАНЗОРИГ

